

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг- Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/НЗ
танай _____ -ны № _____ -г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.ПҮРЭВДАВАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 46,815.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжих дүнгээс 23,660.0 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар цалин олголттой холбоотой 5,030.8 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 44,100.4 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 74 арга хэмжээтэй батлуулж, хэрэгжилтийг 96.4 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан</i>		<i>/төгрөгөөр/</i>	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>311,604,238,04</u>	<u>255,651,732,38</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	94,158,351,51	52,358,335,76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	94,158,351,51	52,358,335,76
3121	Төгрөг	94,158,351,51	52,358,335,76
31211	Төрийн сангийн харилцах	94,158,351,51	52,358,335,76
35	БАРАА МАТЕРИАЛ	215,329,695,92	196,266,936,08
351	Түүхий эд материал	2,712,600,40	1,396,200,40
35110	Тусгай зориулалттай материал	1,979,500,00	1,388,700,00
35130	Эм боох материал	733,100,40	7,500,40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,579,354,17	12,579,354,17
354	Хангамжийн материал	197,832,541,35	170,221,381,51
35410	Бичиг хэргийн материал	2,806,115,37	5,321,715,37
35420	Аж ахуйн материал	111,026,858,40	104,146,327,60
35440	Түлш, шатах тослох материал	23,491,200,00	5,760,000,00
35450	Барилгын засварын материал	10,574,600,00	2,599,760,00
35460	Хүнсний материал	32,857,549,40	31,550,799,40
35470	Бусад хангамжийн материал	17,076,218,18	20,842,779,14
35600	Мал амьтад	2,205,200,00	12,070,000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>816,897,787,20</u>	<u>673,772,788,83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	816,897,787,20	673,772,788,83
392	Биет хөрөнгө	749,613,787,20	606,488,788,83
39201	Барилга, байгууламж, орон сууц	728,493,680,00	728,493,680,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-467,377,385,41	-537,843,079,61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,000,000,00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,000,000,00	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	566,850,438,62	591,965,814,63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-161,599,936,44	-257,105,107,58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,497,099,00	166,165,489,09
39208	Хуримтлагдсан элэгдэл	-94,936,348,50	-107,874,247,54
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,505,000,00	3,505,000,00
39217	Ном	22,686,239,84	22,686,239,84
393	Биет бус хөрөнгө	67,284,000,00	67,284,000,00
39301	Програм хангамж	1,237,000,00	1,237,000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,000,00	-1,237,000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	67,284,000,00	67,284,000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,128,502,025,2</u>	<u>929,424,521,21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>131,181,500,00</u>	<u>89,119,000,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,267,576,00	11,205,076,00
413	Өглөг	52,267,576,00	11,205,076,00
4136	Бусад өглөг	52,267,576,00	11,205,076,00
41361	Байгууллагад төлөх өглөг	52,267,576,00	11,205,076,00

42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,913,924,00	77,913,924,00
422	Урт хугацаат зээл	77,913,924,00	77,913,924,00
4221	Төгрөг	77,913,924,00	77,913,924,00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	77,913,924,00	77,913,924,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	997,320,525,24	840,305,521,21
51	Засгийн газрын хувь оролцоо	997,320,525,24	840,305,521,21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,257,760,70	892,257,760,70
51101	Өмч: - төрийн	892,257,760,70	892,257,760,70
512	Хуримтлагдсан үр дүн	-272,002,953,04	-429,017,957,07
51210	Өмнөх үеийн үр дүн	-272,002,953,04	-272,002,953,04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-157,015,004,03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	377,065,717,58	377,065,717,58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,128,502,025,2</u>	<u>929,424,521,21</u>
		4	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,582,796,852,40	3,127,881,551,96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	157,365,752,40	50,138,951,96
1200	Нийтлэг татварын бус орлого	157,365,752,40	50,138,951,96
120017	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,588,000,00	4,110,301,00
13	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,483,000,00	2,018,400,00
1310	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000,00	2,091,901,00
131001	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	150,570,090,00	30,479,690,00
1311	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	3,207,662,40	15,548,960,96
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,425,431,100,00	3,077,742,600,00
	Улсын төвлөрсөн төсвөөс	2,311,431,100,00	2,971,402,600,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,311,431,100,00	2,971,402,600,00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114,000,000,00	106,340,000,00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	114,000,000,00	106,340,000,00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,490,431,977,04	3,283,088,765,68
	УРСГАЛ ЗАРДАЛ	2,490,431,977,04	3,283,088,765,68
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,421,301,777,04	3,181,696,365,68
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,774,062,094,04	2,349,581,471,98

210101	Цалин	1,102,945,333,31	1,284,280,593,75
210102	Нэмэгдэл цалин	568,024,010,53	883,543,832,23
210103	Унаа хоолны хөнгөлөлт		67,626,800,00
210104	Урамшуулал	103,092,750,20	114,130,246,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,335,403,50	286,915,761,20
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	145,036,103,50	195,707,299,65
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,699,900,00	22,879,567,44
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,799,900,00	11,440,033,83
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	8,799,900,00	11,377,872,14
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,999,600,00	45,510,988,14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,821,187,65	109,778,562,35
210304	Гэрэл цахилгааны зардал	14,292,637,65	17,321,912,35
2104	Түлш, халаалтын зардал	73,528,550,00	87,846,050,00
210401	Цэвэр, бохир усны зардал	3,000,000,00	5,030,600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,112,180,00	27,628,540,80
210401	Бичиг хэргийн материал		10,933,250,00
210402	Тээвэр, шатахууны зардал	8,852,880,00	9,820,760,00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,704,300,00	
210408	Бараа материал актасны зардал	2,555,600,00	6,874,530,80
2105	Нормативт зардал	82,831,787,00	113,863,608,00
210501	Эм	1,082,337,00	841,208,00
210502	Хоол	81,749,450,00	113,022,400,00
210604	Эд хогшил, урсгал засварын зардал	22,372,700,00	31,696,090,00
2107	Урсгал засвар	22,372,700,00	31,696,090,00
210702	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	16,608,273,69	22,648,583,29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,483,000,00	2,018,400,00
210801	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	13,125,273,69	20,630,183,29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,158,151,16	239,583,748,06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,122,206,00	48,721,850,00
210902	Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	13,237,700,00	
210902	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,798,245,16	190,861,898,06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,130,200,00	101,392,400,00
213	Бусад урсгал шилжүүлэг	69,130,200,00	101,392,400,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,048,100,00	75,981,800,00
213204	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	22,082,100,00	25,410,600,00
213208	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213209	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2133	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	92,364,875,36	-155,207,213,72
213303	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	14,744,100,28	1,807,790,31

3	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-14,744,100,28	-1,807,790,31
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-14,744,100,28	-1,807,790,31
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	77,620,775,08	-157,015,004,03

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760,70	377,065,717,58	(272.002.953.04)	997.320.525.24
2	Тайлант үеийн үр дүн			(157.015.004.03)	(157.015.004.03)
3	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,257,760,70	377,065,717,58	(429.017.957.07)	840.305.521.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2.429.724.094.0	3.081.852.901.0
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3.588.000.00	4.110.301.00
	Нийтлэг татварын бус орлого	3.588.000.00	4.110.301.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3.588.000.00	4.110.301.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3.483.000.00	2.018.400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105.000.00	2.091.901.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2.426.136.094.0	3.077.742.600.0
	Улсын төвлөрсөн төсвөөс	2.311.431.100.0	2.971.402.600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2.311.431.100.0	2.971.402.600.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	114.000.000.00	106.340.000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	114.000.000.00	106.340.000.00
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	704,994,00	

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	704,994,00	
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,356,646,538,49	3,104,587,916,75
	УРСГАЛ ЗАРДАЛ	2,356,646,538,49	3,104,587,916,75
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,277,426,744,49	3,006,549,016,75
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,775,470,922,30	2,353,044,248,56
210101	Үндсэн цалин	1,104,354,161,57	1,287,743,370,33
210102	Нэмэгдэл	568,024,010,53	883,543,832,23
210103	Унаа хоолны хөнгөлөлт		67,626,800,00
210104	Үр дүнгийн урамшуулал	103,092,750,20	114,130,246,00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	215,335,403,50	289,070,616,90
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	145,036,103,50	197,862,155,35
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,699,900,00	22,879,567,44
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,799,900,00	11,440,033,83
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	8,799,900,00	11,377,872,14
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,999,600,00	45,510,988,14
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	93,000,000,00	91,340,000,00
210301	Гэрэл цахилгааны зардал	15,000,000,00	16,614,550,00
210302	Түлш, халаалтын зардал	75,000,000,00	69,694,850,00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,000,000,00	5,030,600,00
2105	Нормативт зардал	89,558,250,00	115,069,250,00
210502	Хоол, хүнс	89,558,250,00	115,069,250,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,582,000,00	15,000,000,00
210604	Урсгал засвар	20,582,000,00	15,000,000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,478,273,69	26,314,583,29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,353,000,00	3,148,400,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,125,273,69	23,166,183,29
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,001,895,00	116,710,318,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,764,195,00	106,299,718,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	13,237,700,00	10,410,600,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,219,794,00	98,038,900,00
213	Бусад урсгал шилжүүлэг	79,219,794,00	98,038,900,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	704,994,00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	56,432,700,00	72,628,300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	22,082,100,00	25,410,600,00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	73,077,555,51	(22,735,015,75)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	104,234,405,00	19,065,000,00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	104,234,405,00	19,065,000,00
	Дотоод эх үүсвэрээр	104,234,405,00	19,065,000,00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	104,234,405,00	19,065,000,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(104,234,405,00)	(19,065,000,00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(31.156.849.49)	(41.800.015.75)
22	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	125.315.201.00	94.158.351.51
225	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	94.158.351.51	52.358.335.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<u>Татаас, санхүүжилтийн орлого</u>	3,222,324,600.00	3,081,852,901.00	140,471,699.00	95.6%
Улсын төсвөөс	3,018,217,900.00	2,971,402,600.00	46,815,300.00	98.4%
Орон нутгийн төсвөөс	106,340,000.00	106,340,000.00	0.00	100.0%
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0.00	0.00	
Туслах үйл ажиллагааны орлого	0.00	2,091,901.00	-2,091,901.00	100.0%
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	7,320,500.00	2,018,400.00	5,302,100.00	27.6%
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	90,446,200.00	0	90,446,200.00	
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</u>	3,222,324,600.00	3,081,852,901.00	140,471,699.00	96.4%
<u>Ажиллагчидтай холбогдсон зардал</u>	2,732,201,700.00	2,642,114,865.46	90,086,834.54	88.8%
<u>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</u>	2,428,623,700.00	2,353,044,248.56	75,579,451.44	96.9%
Цалин	1,513,308,900.00	1,287,743,370.33	225,565,529.67	85.1%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	915,314,800.00	1,065,300,878.23	149,986,078.23	143.7%
<u>Нийгмийн хамгааллын шимтгэл</u>	303,578,000.00	289,070,616.90	14,507,383.10	95.2%

Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	255,005,500.00	243,559,628.76	11,445,871.24	95.8%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	48,572,500.00	45,510,988.14	3,061,511.86	93.7%
<u>Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал</u>	91,340,000.00	91,340,000.00	0.00	100.0%
Гэрэл цахилгааны зардал	28,000,000.00	16,614,550.00	11,385,450.00	59.3%
Түлш, халаалтын зардал	59,840,000.00	69,694,850.00	-9,854,850.00	116.5%
Цэвэр, бохир усны зардал	3,500,000.00	5,030,600.00	-1,530,600.00	143.7%
<u>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</u>	299,043,801.00	292,019,201.29	7,024,599.71	82.3%
Хоол	115,069,300.00	115,069,300.00	0.00	100.0%
Бусад бараа үйлчилгээний зардал	121,432,101.00	121,228,818.00	203,283.00	.99.9%
Мэдээллийн технологийн зардал	31,905,200.00	25,462,083.29	6,443,116.71	79.8%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	12,488,800.00	12,110,600.00	378,200.00	97%
Урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,148,400.00	3,148,400.00	0.00	100.0%
<u>Урсгал шилжүүлэг</u>	99,739,100.00	98,038,900.00	1,700,200.00	
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,328,500.00	72,628,300.00	1,700,200.00	97.7%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	25,410,600.00	25,410,600.00	0.00	100.0%
Төвлөрүүлэх шилжүүлэг		0.00	0.00	
<u>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</u>	3,222,324,601.00	3,123,512,966.75	98,811,634.25	
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>		94,158,351.51	-94,158,351.51	
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>		52,358,335.76	-52,358,335.76	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49131.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,030.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 13,682.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 30,417.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Нэр бүхий 3 ажилтанд 2,501.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг холбогдох журмаас илүү тооцож олгосон, 1 ажилтанд 2,529.9 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар

зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоосон

3.2 Албан шаардлага

Багш ажилтнуудыг Улаанбаатар хотын сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулахад төсвөөс 13,682.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг тус тус зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Эд хариуцагч нь тайлант оны хүнсний материалын тайланг алдаатай гаргасан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байна” гэж заасныг зөрчсөн, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

2.Илрүүлэлт:

Үдийн хоолны зардлыг зарцуулахдаа батлагдсан норм нормативыг баримтлаагүй, долоо хоногийн 2 өдөрт нь үдийн хоол хийдэггүй бэлэн бүтээгдхүүнээр үйлчилдэг, хоол зүйч нь тогооч нарын хоолны цэсний мөрдөлтөд хяналт тавиагүй, сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.6-д “Сургуулийн хоол зүйч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг удирдан зохион байгуулж, суралцагч, ажилтан, эцэг, эхэд мэргэжлийн зөвлөгөөг өгнө”, 9.1.4-д “сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн талаар сургуулийн захиргаанд

захиалга, хүсэлт, шаардлага гаргах” гэснийг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үдийн хоолны тогооч нарт хоол зүйчийн боловсруулсан технологийн карт, цэсийг үйл ажиллагаандаа мөрдөж, баримтжуулж хэвших, хоол зүйчид сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүргийг хүргүүлэн, биелэлтийг тооцох;

3.Илрүүлэлт:

Байгууллагад 2025 оны 11 дүгээр сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

1. Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

4.Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын нэгж нь төлөвлөсөн 12 ажлаас 5 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн, алдаа зөрчлийг нэгтгэн дүгнээгүй, зөвлөмж хүргүүлээгүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

5.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 410,179.3 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны тайланг 42,857.3 мянган төгрөгөөр, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 14,004.5 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 148,974.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 11. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий ажилтнуудад ур чадварын нэмэгдэл, ээлжийн амралтын олговрыг илүү тооцож олгосон.	1	5,030.8	1	5,030.8				
Эд хариуцагч нь 2025 онд хүнсний материалын тайланг алдаатай гаргасан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна	1	0.00					1	0.00
Дүн	2	5,030.8	1	5,030.8			1	0.0

Хүснэгт 13. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Багш ажилтнуудыг Улаанбаатар хотын сургуулийн үйл ажиллагаатай танилцуулахад төсвөөс хөрөнгө зарцуулсан	1	13,682.7			1	13,682.7		
Үдийн хоолны зардлыг зарцуулахдаа батлагдсан норм нормативыг баримтлаагүй, долоо хоногийн 2 өдөрт нь үдийн хоол хийдэггүй, хоол зүйч нь хоолны цэсний мөрдөлтөд хяналт хэрэгжүүлдэггүй, сурагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийгээгүй	1	30,417.7					1	30,417.7
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	616,016.0					1	616,016.0
2025 оны 11 дүгээр сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1	0.0					1	0.0
Байгууллагын дотоод хяналтын нэгж үр дүнтэй ажиллаагүй байна.	1	0.00					1	0.00
Дүн	5	660,116.4					5	660,116.4